



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/325

Булган сум

**Гэрээ шууд байгуулах  
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV дүгээр хуралдааны XIV/01 тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаартай захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн Алтаргана-2024 наадмын бэлтгэл ажлыг хангахад шаардагдах үзэгчдийн суудлыг нийлүүлэх нийлүүлэгчээр “Дүгнэнхан Уул” ХХК-ийг сонгож 20,000,000 (хорин сая) төгрөгөөр гэрээ байгуулж, хяналт тавьж хүлээн авахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан барааг чанарын өндөр нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Дүгнэнхан” Уул ХХК (М.Энхжин)-д даалгасугай.

3. Санхүүжилтийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний Алтаргана наадмыг зохион байгуулах зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

4. Гэрээний биелэлтийн дагуу хүлээн авсан барааг бүртгэл хөтөлж, тайлагнахыг Нийтлэг үйлчилгээний алба (Х.Энхбаатар)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

